

БАГШИЙН ЁС ЗҮЙН ТАНДАЛТ СУДАЛГАА

Л. Нямаа, Д. Гүндэгмаа, Г. Сарангэрэл, Т. Цэрмаа
АШУУИС-ийн Говь-Алтай аймаг дахь АУС
Nyamaa@mnums.edu.mn

Судалгааны ажлын үндэслэл

Багш мэргэжлийн үндсэн ёс зүйн хэм хэмжээнүүд нь дэлхий нийтийн хандлагаар өсөн нэмэгдсээр ирсэн байна. Олон улсын Боловсролын Байгууллагаас “Багшийн ёс зүйн мэдлэг нэмэгдсэнээр багш болон боловсролын салбарын ажилтнууд ажилдаа сэтгэл хангалуун байж, тэдний нийгэмд эзлэх байр суурь болон өөрийгөө хүндэтгэх үзэл нэмэгдэж, мэргэжлийн нэр хүндийг өргөхөд хувь нэмэр оруулна” гэж тодорхойлж байгаа нь энэ асуудал боловсролын салбарын тулгамдсан асуудлын нэг гэдгийг харуулж байгаа тул суралцагчдаас тандалт судалгааг тасралтгүй авч байхын чухлыг харуулж байна.

Түлхүүр үг: Багшийн ёс зүй, харилцаа, хандлага, ёс зүйн хэм хэмжээ

Багшийн ёс зүй, түүний үндсэн хэм хэмжээ

Багшийн мэргэжлийн ёс зүй гэж мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой нийтээр хүлээн зөвшөөрсөн итгэл үнэмшил, хэвшсэн соёл болон харилцааны үйлдэл, эс үйлдлийг хэлнэ. Оросын судлаач И.И.Чернокозовын үзлээр багш мэргэжлийн ёс зүйн үндсэн хэм хэмжээнүүдэд дараах ойлголтууд багтаж байна. Үүнд :

- Суралцагсдад хүндэтгэл, шаардлага хоёрыг хослуулах, тэднийг зөв хайрлах, анхаарал тавих
- Суралцагсдынхаа дотоод ертөнц, биеэ авч явах байдлыг үргэлж судалж байх, тэдний боломж, үзэл бодол, авьяас билэгт үргэлж анхаарч өөдрөг хандах
- Биеэ эзэмдэх, тэвчээртэй байх, суралцагсдынхаа алдаа дутагдалд тэвчээртэй байж, засаж залруулдаг байх, суралцагсдаа элэгсэг, найрсаг хандах, үнэнч шударга зарчимч байх
- Шавь нартаа зөв үлгэр дууриалал үзүүлэх, биеэ зөв авч явах эдгээр болно хэмээжээ.

Судалгааны арга зүй

Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын ЕБС-ийн ахлах ангийн сурагчдаас санамсаргүй түүврийн аргаар хаалттай асуумж судалгаа авч, Ликертийн үнэлгээгээр үнэлэв. Судалгаанд ГАА-ийн Есөнбулаг сумын 12 жилийн сургалттай 1, 2, 3, 4-р сургууль болон АШУУИС-ийн ГАА дахь Лицей ахлах сургуулийн нийт 914 суралцагчдын төлөөлүүлж 282 сурагчдыг хамруулсан нь 30,8%-ийг эзэлж байна. Бидний судалгаа нь хаалттай асуумж бүхий 3 бүлэг 23 асуулттай. Үүнд:

- 1-р бүлэг: Сурагчдын ерөнхий мэдээлэл /3 асуумж/
2-р бүлэг: Ликертийн үнэлгээгээр үнэлэх боломж бүхий хаалттай асуумж /16/
3-р бүлэг: Ликертийн үнэлгээгээр үнэлэх боломжгүй хаалттай асуумж /4/ байсан болно.

Судалгааны үр дүн

График 1. Судалгаанд хамрагдагчид /анги, сургуулиар/




График 2. Судалгаанд хамрагдагчдын хүйсний байдал




График 3. Багш нарын сургалтын ур чадварт өгсөн үнэлгээний харьцуулалт




График 4. Мэдлэг бүтээлгэх чадварыг эрдэмтдийн судалгаатай харьцуулсан байдал



График 5. Багшийн үнэлгээний бодит байдлын харьцуулалт




График 6. Үнэлгээний бодит байдлыг эрдэмтдийн судалгаатай харьцуулсан байдал



- ЕБС-ийн багш нарын СХ-х үр чадварт сурагчид маш сайн, сайн үнэлгээг 80 гаруй хувьтайгаар үнэлсэн нь сайшаалтай байна.
- Багш нарын мэдлэг бүтээлгэх чадварыг Болормоа нарын судалгаатай харьцуулахад маш сайн үнэлгээ доогуур, сайн ба дунд үнэлгээ их байна.
- Багшийн үнэлгээ тийм ч бодитой биш гэж 22% , үнэлгээнд хөндлөнгийн нөлөө байгаа хэмээн 71%, хувийн харилцаагаа дүнтэй холбодог гэж 23% нь үзсэн байгаа нь анхаарах асуудал байна.
- Үнэлгээний бодит байдал нь бусад судлаачдын судалгаатай ойролцоо байна.

График 7. Багш нарын гадаад төрхөд өгсөн үнэлгээ




График 8. Багш нарын сурган хүмүүжүүлэх харилцаанд өгсөн үнэлгээ




График 9. Багш сурагчдын сөрөг харилцааны байдал





График 10. Багш нарын харьцаа, хандлагыг эрдэмтдийн судалгаатай харьцуулсан байдал



- Багшийн гадаад төрх нь сайнаас дээш үнэлгээтэй байгаа нь эерэг үзүүлэлт байна.
- Сурагчид багш нарын СХ-х харилцаа төгс биш ялгаварлах үзэл байдаг хэмээн 51%, сурагчдын үзэл бодлыг сонсож хэрэгжүүлэх ажил зохион байгуулах, хөгжүүлэх боломж олгох, сурагчдыг хүндэтгэх байдал дундаас доогуур гэж судалгаанд хамрагдагчдын 1/3 нь үзсэн байгаа нь тааруухан үр дүнг харуулж байгаа тул цаашид энэ талаар ажил зохион байгуулах хэрэгтэйг харуулж байна.
- Багш нар сурагчидтай зүй бусаар харьцах үзэгдэл үргэлж байдаг гэж 52%, хэл амаар доромжлох, биед халдах тохиолдол хааяадаа гарсаар байдаг гэж 35%-аас дээш хувь нь үнэлсэн байгаа нь ёс зүйн хувьд тохирохгүй байна.
- Харин ЕБС-д авилгал байхгүй байгааг судалгаа харуулж байна.
- Багш нарын харьцаа хандлагын судалгааг Болормоа нарын судалгаатай харьцуулахад маш сайн, муу үнэлгээ доогуур байхад дунд гэсэн үнэлгээ их байна.

Хэлцэмж

Багшийн ёс зүйн талаар шат шатны боловсролын байгууллагад хийсэн судалгаа нэлээдгүй байгаагаас Ш.Оюунцэцэг З.Чулуунбат Г.Очирболд нарын УБ хотын Багануур дүүргийн багш нарын дунд хийсэн “Багш мэргэжилтний ёс зүйн өнөөгийн түвшин, сайжруулах арга зам” судалгаанд багш нарын ёс зүйн түвшинг маш сайн, маш муу гэж үзсэн тохиолдол гараагүй, харин боломжийн түвшинд байгаа гэж 72 хувь нь, дунд зэрэг гэж 28 хувь нь үзсэн байна. Болормаа нарын ЕБС-ийн ахлах ангийн сурагчдаас авсан судалгаанд багш нарын мэдлэг бүтээлгэх чадвар, үнэлгээний бодит байдал 80 орчим хувьтай, харин харьцаа хандлага дундаж гэсэн үзүүлэлттэй гарсан байна. Наранчимэгийн багшийн ёс зүйн хэм хэмжээг цэцэрлэгийн багш нарын дунд судалж үзэхэд мөн дундаж хэмжээнд байна гэсэн дүгнэлт гарсан байна. Бидний судалгааны ихэнх үзүүлэлт дээрх судлаачидтай ойролцоо гарсан.

Дүгнэлт

-ЕБС-ийн багш нарын хувьд сурган хүмүүжүүлэх ур чадвар, багш нарын гадаад төрх сайн байна.

- Харин ёс зүйн гол үзүүлэлт болох сурагчдыг үнэлэхдээ хөндлөнгийн нөлөө, хувийн харьцаа гаргадаг, тэднийг ялгаварлах, хэл амаар доромжлох, зүй бусаар харьцах үзэгдэл гаргасаар байгаа нь “Багшийн ёс зүйн хэм хэмжээ”-г зөрчих асуудал харилцааны хэмжээнд байна гэж дүгнэж байна.

Судалгааны практик ач холбогдол

Багшийн ёс зүйн тандалтын энэхүү судалгаа нь ЕБС-ийн багш нарыг сурагчдынх нь үзэл бодлоор хөндлөнгөөс үнэлсэн бодит үнэлэмж тул багш нарын хувьд ажилдаа санамж авч анхаарч ажиллах боломжийг бүрдүүлэх төдийгүй бусад судлаачдад судалгааны материал болох ач холбогдолтой.

Цаашид дэвшүүлэх санал

- Багш мэргэжилтний ёс зүйн гажуудлын үндсэн шалтгаан нь боловсролын систем юм. Одоог хүртэл үргэлжилж ирсэн сургалтын агуулга нь их байдаг нь хэдхэн хүүхдийг хичээл ойлгоход хүргэдэг. Иймээс хичээлээ ойлгоогүй сурагчидтай зөрчилддөг.

- Өнөөгийн нийгэмд хүүхдийн хүмүүжилд анхаарахгүй байгаа нь сурах бэрхшээлийг сурагчид даван туулах чадвар сул байна.

- Багшийн ёс зүйн зөрчил багшийн өөрийн нь хувийн зан чанартай холбоотой байх магадлал судалгаанаас харагдаж байгаад дүгнэлт хийж сургалт зохион байгуулах хэрэгтэй байна.

Ном зүй

1. Дарьхүү, Р., & Гаадмаа, Ч. (2005). Багш мэргэжлийн ёс зүйн асуудалд. Боловсрол судлал сэтгүүл, МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг.
2. Олон Улсын Боловсролын Байгууллага. (2018). Багшийн ёс зүй. Боловсрол судлал, Улаанбаатар.
3. Содномгомбо, Д., & Дарьхүү, Р. (2004). Философи. Улаанбаатар.
4. Тунгалаг, Д. (2020). Ёс зүй. Улаанбаатар.
5. Тунгалаг, Д. (2007). Мэргэжлийн ба хэрэглээний ёс зүй. Улаанбаатар.
6. Bowman, J. S., & Mezel, D. C. (1998). Teaching Ethics.